

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛД

*О.Алтангэрэл, дэд профессор,
У.Лхагвадорж, магистр, ШУТИС*

Abstract

A fundamental basis of higher education quality management is a diagnostic analysis of the results of learning and teaching. Since learning is a technological process using input-process-output model, the comparison of the true outcome against objectives is the necessary step and shall guide the further improvement. It is implemented through learning assessment. The actuality and significance of this function lies here. Learning assessment is the indicator of the achievement, and a key to the development. In this paper the current status of the learning assessment in higher education institutions is reviewed based on the questionnaire results taken from students, faculty staff. Certain negative factors are detected from the study and proposals to overcome are suggested. From the study it is observed that within three factors namely education management, teacher and students we need to explore the founding drives to shift the current system into assessment based one and this should base on the findings of scientific studies. The current practice of assessment of knowledge and skill achievement is mainly based on exam results should be changed into the assessment of competence, skill and attitude which requires a need of centralized assessment system. This is the issue of the overcoming a conflicting principle of differing perspectives of new and old of assessment of achievement of objectives set on education process.

Түлхүүр үг

Сургалтын үр дүн, сургалтын үнэлгээ, үнэлгээний бодит байдал, үнэлэх шалгуур

Удиртгал

Улс орны хөгжлийг шийдвэрлэгч хүчин зүйлүүд дотроос боловсрол нь хувьсгагч шинжтэй бөгөөд, чанартай боловсрол бүхий иргэд нь тухайн нийгмийн хөгжил дэвшлийн баталгаа болж байдаг. Чанартай иргэн төлөвшлийн нэн чухал талыг албан боловсролоор олгодог. Энэ үүднээс үзвэл боловсрол, тэр дундаа дээд боловсролын чанар үр өгөөж, хүртээмж нь дэлхийн улс орнуудын хил зааггүй орон зайг хамарсан өрсөлдөөний шинэ хэлбэр болох хандлагатай байна. Аливаа өрсөлдөөн нь хөгжлийн түлхэх хүчийг агуулдаг. Манай улсын дээд боловсролын зорилго ч дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий, бүтээмжийн агуулга өндөртэй мэргэжилтэн бэлтгэхэд чиглэж байна. Боловсролын хөгжил нь тасралтгүй үйл явц бөгөөд хүн төрөлхтний хөгжлийн өнө эртнээс өнөөг бүтээсний уг сурвалж хэмээн үзэж болно. Боловсролд, зорилгоо дэвшүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь нь өнөөгийн хүрсэн түвшнээ зөв тодорхойлж, оношлоход оршино. Энэ нь сургалтын практикт шалгалт, үнэлгээгээр хэрэгждэг. Үүнд сургалтын үр дүнгийн үнэлгээг боловсронгуй болгох асуудлын ач холбогдол оршино. Судлаач С.Санжаабадам (2006.х-72): “Үнэлгээний аргазүйн хөгжлийн ерөнхий хандлагыг харахад тухайн үнэлгээний үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг ихээхэн анхаарч байна” хэмээн сургалтад хэрэгжүүлж буй үнэлгээний үр ашгийг нэмэгдүүлэхийн чухлыг тэмдэглэсэн.

Үнэлгээний үр ашиг гэдгийг бид юуны өмнө түүний үнэн бодит чанартай холбон үзэж байна. Сургалтын үр дүнгийн оношилгоог ээлжит хичээлийн, сэдэв бүлгийн, хичээлийн хөтөлбөрийн, мэргэжлийн хөтөлбөр- сургалтын төлөвлөгөөний түвшинд авч үзэж болно. Дээд боловсролын хөгжил, нийгэмд гүйцэтгэх үүрэгтэй холбогдон, сургалтын үнэлгээний зохион байгуулалт, арга технологид иж бүрэн шинэчлэл хийх хэрэгцээ урган гарч байна. Сургалтын үнэлгээг өөрчлөн боловсронгуй болгох асуудлыг авч үзэхдээ үнэлгээний үүрэг, ач холбогдол, мөн чанарыг ойлгох нь чухал. “Үнэлгээ бол ямар нэг урьдаас төлөвлөсөн, одоо үргэлжилж байгаа, эсвэл хийж дууссан үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн үнэ цэнэ, ач холбогдлыг аль болохоор системтэй, бодитой тодорхойлох үйл явц юм” (Линда, Морра Имас, Рей С,Рист, 2011.х-7). Үнэлгээний зохион байгуулалт, агуулга, арга хэлбэр нь түүний зорилготой нягт уялдсан байх хэрэгтэй юм. “Бодитой хийсэн үнэлгээ нь сурах, сургах үйл ажиллагааны технологийн зохицол, түүний оновчтой байдал, тавьсан зорилго, зорилтын бодитой эсэхэд үнэлгээ, дүгнэлт, засвар тохируулга хийх чухал үе шат юм” (Алтангэрэл, 2008, х-66). Өмнө нь бид мэдлэгт суурилсан хяналт үнэлгээний систем, аргыг голчлон хэрэглэж байсан бол өнөөгийн нөхцөлд чадвар, чадамж, хандлагыг үнэлэн, хэмжих хэрэгцээ


тавигдаж байна (Мөнхжаргал, 2016, х-12): “Мэдлэг, чадвараас гадна хандлага, төлөвшлийг хэмжих асуудал хамгийн түвэгтэй нь юм. АНУ-ын эрдэмтэд хандлагыг санал бодол (opinions), итгэл үнэмшил (belief), хандлага (attitude) гэсэн шатлалаар үүсдэг гэж үздэг. Энэ загварчлалын дагуу хандлага, төлөвшлийг хэмжиж болох юм” гэсэн санаа дэвшүүлсэн байна. Чадвар чадамж, хандлагын төлөвшил нь хүний оюун, сэтгэхүйн гүнд түүний дотоод мөн чанараар, тодорхой зүй тогтлын дагуу бүтээгдэх дээд эрэмбийн нарийн нийлмэл бүтээгдэхүүн тул түүний илэрцийг хэмжиж тодорхойлох нь, мэдлэгийг үнэлэх аргазүйгээс ихээхэн ялгаатай байх болно. Аливаа шинэ зорилгыг оновчтой дэвшүүлэн, хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл нь юмс үзэгдэл, үйл явцын тухайн агшны төлөв байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг оношлон тодорхойлоход оршино. Энэ учир зүйн үүднээс манай улсын дээд боловсролын сургалтын үнэлгээ хэрхэн явагдаж

байгаа ерөнхий дүр зургийг гаргах, энэ үндсэн дээр тулгуурлан уг ажлыг одоогийн шаардлагад хэрхэн нийцүүлэн, сайжруулах талаар их, дээд сургуулийн багш, судлаачдын санал дүгнэлт, туршлагыг нэгтгэн дүгнэх зорилгоор онлайн судалгааг төрийн ба хувийн өмчийн 20 гаруй их, дээд сургуулийн 140 гаруй багш, судлаачид, МУИС, ШУТИС, МУБИС, ХААИС, АШУУИС, СУИС-ийн 500 оюутныг хамруулан явуулав. Судалгаанд оролцсон багш нарын 30% нь доктор (Ph.D), 2% нь доктор (Sc.D) зэрэгтэй, 70 гаруй хувь нь дээд боловсролын салбарт 10-аас дээш жил ажилласан хүмүүс байлаа. Багш нараас судалгааг онлайнаар, оюутнаас бичгээр асуулгын хэлбэрээр авсан. Судалгаанд сурах үйлийн үнэлгээний бодит чанар, арга хэлбэр, түүнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодруулж, шинжилгээ, дүгнэлт хийхийг зорьсон юм.

Судалгааны үр дүн

График 1

Сурах үйлийн үнэлгээний зохион байгуулалт, арга хэлбэр нь дээд боловсролтой мэргэжилтэнд тавигдах өнөөгийн шаардлагатай хэрхэн нийцэж байгаа үзүүлэлт




Эх сурвалж: Дээд боловсролын чанарын асуудлаар ИДС-ийн багш нарын дунд явуулсан онлайн судалгааны баримт, мэдээлэл 2016. ДБСМН, МИДСК.

Судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь сургалтын үнэлгээ нь дээд боловсролтой мэргэжилтэнд тавигдах өнөөгийн шаардлагатай нийцэхгүй байна гэж дүгнэсэн нь үнэлгээний үйл ажиллагааг шинэчлэн боловсронгуй болгох нийгмийн шаардлага байгааг харуулж байна.

График 2

Сурах үйлийн үнэлгээний бодит байдлын үзүүлэлт



Эх сурвалж: Дээд боловсролын чанарын асуудлаар 20 гаруй ИДС-ийн 140 багш, Төрийн 5 их сургуулийн 500 оюутнаас авсан судалгааны баримт, мэдээлэл 2016. ДБСМН, МИДСК.

Үнэлгээний бодит байдлын талаар багш ба оюутны судалгаанд өгсөн дүгнэлт ойролцоо байгаа нь өнөөгийн байдлыг зөв тусгасан гэж үзэж болохоор байна. Судалгаанд оролцогч багш, оюутны 40 гаруй хувь нь сургалтын үнэлгээ ихэнх тохиолдолд бүхэлдээ бодитой биш байдаг гэж дүгнэсэн. Энэ нь үнэлгээ үнэн бодитой байх үндсэн шаардлагаа бүрэн хангахгүй байгааг

харуулж байна. Бодитой биш, хуурамч үнэлгээний сөрөг нөлөө, үр уршгийг бид боловсролын чанар болон олон зүйлтэй холбон авч үзэж болно.

Сурах үйлийн үр дүнг үнэлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа гол гурван хүчин зүйлийг судалгааны үр дүнгээс харвал (График 3).

График 3


Сурах үйлийн үнэлгээнд сөрөг нөлөөлж байгаа үндсэн хүчин зүйлүүд



Энэ үзүүлэлт нь багшаас авсан судалгааны мэдээлэлд үндэслэсэн бөгөөд, оюутны талын хүчин зүйл дийлэнх хувийг эзэлж байна. Үндсэн хүчин зүйл тус бүрийг судалгаанд оролцсон багш нарын саналын давтамжаар нь асуудлуудыг эрэмбэлж, графикаар харуулав (График 4, График 5, График 6).

График 4

Сурах үйлийн үнэлгээнд оюутны талаас сөрөг нөлөөлж байгаа хүчин зүйлүүд




Оюутны талаас сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг 11 асуудалд задалж, багш нараас өгсөн дүгнэлтийн давтамжаар эрэмбэлэн, графикаар үзүүлж байна.

Үнэлгээ, шалгалт нь сурах үйлийн чухал хэлбэр тул оюутнууд түүнд онцгой ач холбогдолтой хандаж, шалгалт, үнэлгээний мөрөөр дутуу дулимаг зүйлээ сурч, мэдэхийн төлөө ажиллахгүй, тэр чигээр нь орхидог.

Үнэлгээний үр дүнд оюутны сурч эзэмшсэн болон дутуу зүйл ялгаран тодордог тул оюутнаас зорилго, үйл ажиллагааныхаа хүрээг шинээр төлөвлөж, ажиллах боломжийг олгодог. Ихэнхдээ энэхүү боломжийг анхаарч, үр дүнтэйгээр ашиглахгүй байна.

График 5

Сурах үйлийн үнэлгээнд багшийн талаас сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйл




Багшийн талаас сөрөг нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалгаанд оролцогчдын дүгнэлтийн давтамжаар 4 асуудалд задлан графикаар үзүүлэв. Үнэлгээ, шалгалтад багшийн хувийн субъектив хандлага голлох үүрэгтэй байж, оюутны тооны хэт

ачаалал зэргээс шалтгаалж, оюутан бүртэй жигд, хүртээмжтэй ажиллах боломж хязгаарлагдмал байна. Мөн багшийн санаачлаг, идэвх хандлага, туршлага, чадвар чухал үүрэгтэй юм.

График 6

Сурах үйлийн үнэлгээнд сургуулийн талаас сөргөөр байгаа хүчин зүйл




Сургуулийн талаас сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалгаанд оролцогчдын дүгнэлтийн давтамжаар 5 асуудалд задлан эрэмбэлж хувиар үзүүлэв. Үнэлгээний асуудалд сургууль, салбар тэнхимээс нэгдсэн хяналт, зохион байгуулалтын талын ажлыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Шалгалт-үнэлгээний

агуулга, арга хэлбэр, шалгуур, үр дүн зэрэг нь суралцагсдад тодорхой, нээлттэй байхын зэрэгцээ, үнэлгээ нь бодитой үнэн зөв, шударга, сургалтын зорилтуудтай уялдсан байх зэрэг үндсэн шаардлагыг хангах, үнэлгээнд судалгаатай хандаж, түүнийг үйл ажиллагаандаа ашиглах нь чухал байна.

График 7

Хөндлөнгийн нөлөөллөөр багш бодит биш, хийсвэр үнэлгээ өгдөг байдлын үзүүлэлт




Эх сурвалж: Дээд боловсролын чанарын асуудлаар ИДС-ийн багш нарын дунд явуулсан онлайн судалгааны баримт, мэдээлэл 2016. ДБСМН, МИДСК.

Багшийн үнэлгээнд хөндлөнгөөс нөлөөлөх явдал цөөнгүй биш байдаг нь судалгааны дүн болон ажиглалтаас батлагдаж байна. Энэ нь багшийн хөдөлмөрийг үнэгүйдүүлж, тэдний бүтээлч идэвхтэй ажиллагааг бууруулахын зэрэгцээ, оюутны ёс суртахууны төлөвшил, бүтээлчээр сурах идэвхийг бууруулж байгаа зохисгүй үзэгдэл юм.

Үүнийг багш, оюутны хандлага, сэтгэлгээний өөрчлөлт, зохион байгуулалтын хүсэл зоригоор бүрэн таслан зогсоож, шийдвэрлэж болох асуудал билээ.

График 8

Хичээл, сургалтад оюутны оролцооны үзүүлэлт




Эх сурвалж: Дээд боловсролын чанарын асуудлаар Төрийн 5 их сургуулийн 500 оюутнаас авсан судалгааны баримт, мэдээлэл 2016. ДБСМН, МИДСК

Суралцах үйл үр дүн сайтай, чанартай байх үндсэн нэг нөхцөл нь суралцагч өөрөө сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй, бүрэн оролцож, системтэй ажиллах асуудал байдаг. Судалгаанд оролцсон багш нарын дүгнэлтээр сургалтад амжилт гаргахгүй байх нэг шалтгааныг оюутнууд хичээл сургалтдаа бүрэн оролцдоггүйтэй холбон үзсэн.

Бидний судалгаанаас үзэхэд оюутны дийлэнх хувь нь хичээлд хагас дутуу оролцдог байна. Энэ нь олон талын шалтгаантай байж болох бөгөөд, голлох шалтгааныг илрүүлэн түүнийг засах чиглэлд удирдлага, зохион байгуулалт, аргазүйн үйл ажиллагаа шаардагдаж байна.

График 9

Оюутны ном, сурах бичиг ашиглалтын байдал




Өмнөх үеийнхний бүтээн туурвисан эрдэм мэдлэг, туршлагаас суралцан эзэмшиж, боловсрох үндсэн эх сурвалж нь ном, сурах бичигтэй ажиллах асуудал бөгөөд, дээд боловсролын суралцахуйн нэн чухал, дээд хэлбэр мөн. Дээд боловсролд суралцагчийн үйл ажиллагааны онцлог тал нь энэ байх юм. Энэ үүднээс бидний судалгаанд уг асуудлыг хөндсөн болно.

Судалгаанд хамрагдсан хот, хөдөөгийн их, дээд сургуулийн 500 оюутны 60% нь ном, сурах бичгийг зөвхөн зарим хичээлд хааяа ашигладаг, 2% нь огт ашигладаггүй, 18% нь бүх хичээлд байнга ашигладаг байна. Ном, сурах бичигтэй ажиллахыг сургалтын салшгүй бүрэлдэхүүн болгож, түүний хүрэлцээ хангамж, чанарыг анхаарах нь чухал байна.

График 10


Оюутны шалгалтад бэлтгэж оролцдог байдал



Оюутнаас шалгалтад хариуцлагатай бэлтгэж оролцох нь түүний сурах үйлийн зорилго, хандлага, төлөвшилтэй, нөгөө талаар сургалтын зохион байгуулалт, технологи, багшийн арга барилтай холбоотой асуудал юм. Судалгаанаас үзэхэд оюутны 67% нь шалгалтад бага зэрэг бэлддэг, 9% нь огт бэлддэггүй, өөр арга зам хайдаг, зөвхөн 23% нь улирлын турш жигд ажилладаг байна. Шалгалт үнэлгээ нь сургалтын салшгүй хэсэг, онцгой хэлбэр мөн. Иймээс шалгалтыг сурах үйлийг идэвхжүүлэн, мэдлэг чадварыг дүгнэн цэгцэлж, гүнзгийрүүлэн, хөгжүүлэх хэрэгсэл болгож ажиллахад анхаарах шаардлагатай байна.

График 11

Оюутны сурах үйлийн чанарт сөрөг нөлөөлж байгаа хүчин зүйлүүд (Судалгаанд оролцсон оюутнуудын өгсөн дүгнэлт, санал)



Дээд боловсролын хэрэглэгч тал оюутны санал, дүгнэлтийг өгсөн саналын давтамжийн хувиар эрэмбэлж графикаар үзүүллээ. Энд багшийн заах аргазүй, хичээлийн чанар хангалтгүй 38%, оюутны суурь мэдлэг хангалтгүй 36%, оюутны сурах идэвх хангалтгүй, багшийн зөвлөн туслах ажиллагаа хангалтгүй тус бүр адил 28%, ном сурах бичиг ховор, хүрэлцээгүй, мэргэжлээ зөв сонгоогүй, идэвх сонирхолгүй тус бүр 27% сургалтын амжилтад хамгийн их сөрөг нөлөөлж буй хүчин зүйлүүд бөгөөд, эдгээр нь график 4-д үзүүлсэн багшийн дүгнэлттэй ойролцоо байгаа нь, тухайн нөхцөл байдлыг үндэслэлтэй тусгасан гэж үзэхээр байна.

Судалгаанд оролцсон багш нараас оюутны үнэлгээнд хэрэгжүүлж буй зарим арга барил, чиг хандлага:

1. Оюутны ахиц, хөгжлийн түвшнийг илэрхийлэх, жигд, үр бүтээлтэй ажиллуулахад чиглэсэн сэдэв, бүлгийн хяналтыг тогтмол хийж, оюутан бүрийн хөгжлийн мэдээллийн сан бүрдүүлж, улирлын эхэнд-дунд-эцэст харьцуулсан дүн шинжилгээ хийж, судалгаатай ажилладаг.
2. Үнэлгээний агуулга, аргачлалын тодорхой, нээлттэй, уян хатан байдлыг хангах, суралцагч өөрийн чадвар, хурданд тохируулах боломж олгох.
3. Сургалтын үнэлгээнд оюутны төлөвшил, хандлагын төлөв байдлыг харгалзах

4. Эзэмшсэн мэдлэгийн хэрэглээ, хийсэн зүйл, бүтээл тэдгээрийн тайлбар хамгаалалтыг гол болгох
5. Оюутанд үнэлгээний ач холбогдлыг ойлгуулах, сурах үйлийн энэ онцгой хэлбэрийн зохион байгуулалт, явцад оюутны оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаардаг.
6. Оюутны мэдлэг, чадвар эзэмшилт, хандлага төлөвшилтийн түвшнийг бодитой үнэлэх чухал хэлбэр болох ярилцлага, эсээ бичиглэл зэргийг сургалтын үнэлгээнд өргөн хэрэглэж байна.
7. Шалгалт үнэлгээ нь мэдлэг, чадварыг дүгнэн цэгцлэх, сурах үйлийг идэвхжүүлэх чухал хэлбэр учир зарим багш нар шалгалт үнэлгээний дараа түүний мөрөөр оюутантайгаа хамтарч ажиллахад анхаардаг байна.

Санал зөвлөмж

Сурах үйлийн үнэлгээний системийг өөрчлөн шинэчлэх нь боловсролын суурь онол, үзэл баримтлал, сургалтын үйл ажиллагааны бүтээлч туршлагад тулгуурлан бүтээгдэж, хөгжиж байх нарийн түвэгтэй динамик үйл явц юм. Иймээс энэ ажилд удирдлага зохион байгуулалтын болон багш сурган хүмүүжүүлэгчдийн идэвх санаачлалыг дэмжих, бүтээлч туршлагыг нэгтгэн дүгнэх, төсөл судалгааг хэрэгжүүлэх зэрэг ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Бидний судалгаагаар тогтоогдсон сургалтын үнэлгээнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг засан сайжруулах асуудлыг сургууль, холбогдох субъектүүд анхааран ажилласнаар сургалтын үйл ажиллагаа чанаржих юм.

Дүгнэлт

1. Дээд боловсролын сургалтын үнэлгээг өөрчлөн шинэчлэх шаардлага нь доорх байдлаар нөхцөлдөж байна:
 - Дээд боловсролын үүрэг зорилгын шинэчлэл ба үнэлгээний хуучин арга хэлбэрийн зөрчлийг шийдвэрлэх зорилт тулгарсан,
 - Судалгаанд оролцсон багш, оюутны 40 гаруй хувь нь сургалтын үнэлгээний зохион байгуулалт, дүрэм журам, арга хэлбэр нь тохиромжгүй, сургалтын үнэлгээ ихэнх тохиолдолд буюу ер нь үнэн зөв, бодитой байдаггүй гэж дүгнэлт өгсөн,
 - Сургалтын үр дүнгийн бодит үнэлгээ нь сургалтад чанарын удирдлагыг хэрэгжүүлж, хөгжлийн зорилт, арга замыг тодорхойлоход чухал үүрэгтэй сургалтын онцгой хэлбэр мөн,
2. Боловсролын үнэлгээний шинэчлэлийг сургалтын шинэ зорилт, шаардлагатай уялдуулан, мэдлэг, чадвар дүгнэдэг хуучин

хэлбэрээс чадвар чадамж, хандлагын хөгжлийг үнэлж, хэмжихэд төвлөрсөн сургалтын ажлын зохион байгуулалт, дүрэм журам, сургалт-үнэлгээний технологи, арга хэлбэр, багшийн хандлага, ойлголт, оюутны оролцоо зэргийг хамруулан цогцоор шийдвэрлэх шаардлагатай байна.

3. Сургалтын үнэлгээний шинэчлэлийн нарийн түвэгтэй байдлаас шалтгаалж, “Чадвар-чадамж, хандлага”-ын хөгжил, төлөвшлийг үнэлж хэмжих ерөнхий шалгуур-үзүүлэлтийг судалгааны үндэстэй тодорхойлох нийгэм, боловсрол судлал, сэтгэл судлаач эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй судалгааны баг ажиллуулах нь зүйтэй байна.
4. Сургалтын үнэлгээний шинэчлэлд сэдэв бүлэг, хичээлийн ба хөтөлбөрийн бүх түвшинд орц-явц-гарцыг хамарсан тодорхой шалгуур бүхий, нээлттэй, үнэн бодит мэдээллийг агуулсан, хэрэгжүүлэх баялаг арга хэлбэр бүхий, бүтээлч туршлагаар баяжиж байдаг, сургалтын онцгой хэлбэрийн түвшинд хүргэх шаардлага тавигдаж байна.
5. Бидний судалгааны дүнгээс сургалтын үнэлгээний чанар, бодит байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг оюутны ба багшийн хандлага-үйл ажиллагааны дутагдал, сургалтын зохион байгуулалт-дүрэм журмын үл зохицол, боловсронгуй биш байдал гэсэн гурван үндсэн чиглэлд нарийвчлан судалж, үйлийн судалгааны хэлбэрээр, багш нарын бүтээлч туршлагад тулгуурлан, боловсронгуй болгох нь чухал байна.

Ашигласан материал

- Санжаабадам, С. (2006). *Боловсролын чанарын үнэлгээ*. Улаанбаатар
- Линда Г, Морра Имас, Рей С, Рист. (2011). Үр дүнд хүрэх зам. Хөгжлийн үнэлгээг үр дүнтэй удирдан явуулах нь
- Алтангэрэл, О. (2008). Сургалтын хөтөлбөрийг хэрэглээ төвтэй боловсруулах аргазүйн зарим асуудал. Диссертаци. Улаанбаатар
- Мөнхжаргал, Д. (2016). Боловсролын үнэлгээ /international conference on educational evaluation/
- “Дээд боловсролын чанарын асуудал”
- Их, дээд сургуулийн багш нараас авсан онлайн судалгаа. <http://www.maher.org.mn>.
- “Дээд боловсролын чанарын асуудал”
- Төрийн өмчийн 5 их сургуулийн 500 оюутнаас авсан судалгаа. 2016. <http://www.maher.org.mn>.

Талархал

Манай судалгаанд ач холбогдол өгч, оролцсон нийт багш, ажилтан, оюутнуудад талархлаа илэрхийлье.